



2018 он 12 сар 1 өдөр

/Хурал 2/18

Хурлын үйл ажиллагаа

АРД ДААТГАЛ ХК-ИЙН ХУВЬЦЛАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Хурлын огноо: 2018 оны 12 сарын 1-ний өдөр;

Хурлын байршил: Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо, Ерөнхий Сайд Амарын гудамж-2, Туушин зочид буудлын 5 дугаар давхар, Соёмбо танхим;

Хурал эхэлсэн цаг: 14 цаг 15 минут;

Хурлын дарга: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга Ч.Ганхуяг;

Хуралд оролцсон хувьцаа эзэмшигчдийн тоо: 131 хүн;

Хурлын ирц: Нийт саналын эрхтэй хувьцааны тоо 25,000,000 ширхэг, хуралд оролцож буй хувьцаа эзэмшигчдийн саналын эрхтэй хувьцааны тоо 18,488,094 ширхэг буюу 74.25%.

Хурлаар хэлэлцэх асуудал:

1. Дүрмийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх тухай;
2. Компанийн дүрмийг батлах тухай;
3. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүнийг сонгох тухай.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг нээж, хуралд хүрэлцэн ирсэн хувьцаа эзэмшигчдэд талархал илэрхийлье. Ард Даатгал ХК нээлттэй, санхүүгийн хувьд ил тод компани болохын хувьд татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, гуравдугаар улирлын санхүүгийн тайлан, компанийн үйл ажиллагаатай

холбоотой бусад мэдээллийг хувьцаа эзэмшигчиддээ нэг дор хүргэх, санал, мэдээлэл солилцох, Санхүүгийн Зохицуулах Хорооны шаардлагын дагуу компанийн дүрмийн санг 1,500,000,000 (нэг тэрбум таван зуун сая) тогроогоор нэмэгдүүлж, 5,000,000,000 (таван тэрбум) тогрог болгон нэмэгдүүлэх, түүнтэй холбогдуулан компанийн дүрмийг батлах, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хараат бус гишүүдийг сонгох асуудлыг хурлаар хэлэлцэж шийдвэр гаргангаана

Хуралд хүрэлцэн ирсэн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн, Б.Болортуяа, Б.Золбоо, Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах, Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд нарыг танилцуулав.

Тооллогын Комиссын дарга Д.Энхбилэг: Нийт саналын эрхтэй 25,000,000 ширхэг хувьцааг эзэмшигчээс саналын эрхтэй 18532501 ширхэг хувьцааг эзэмшиж буй 131 хувьцаа эзэмшигч итгэмжлэлийн үндсэн дээр болон өөрийн биеэр хуралд хүрэлцсэн ирсэн буюу хурлын ирц 74.13 хувьтай тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай.

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд: Хурлын материалд тусгасан дэгийн дагуу хурал хуралдана, товчхондоо компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлан, хурлаар хэлэлцэх асуудлуудтай холбогдох танилцуулга хийгдэнэ. Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх)-ийн хараат бус гишүүнд нэр дэвшигчийн материалыг хурал хуралдахаас нэг сарын өмнө хүлээн авахаар өдөр тутмын сонин, компанийн веб сайтаар дамжуулан олон нийтэд зар хүргэсэн ч нэг нэр дэвшигч материалаа ирүүлснийг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дэргэдэх Засаглал, Нэр дэвшүүлэх, Цалин урамшууллын Хороогоор хэлэлцүүлж, нэр дэвшигч зохих шаардлагыг хангаагүй гэж үзээд тус Хорооны шийдвэрээр Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлаар хэлэлцүүлэх шаардлагагүй гэж үзсэн тул хурлаар энэ асуудлыг хэлэлцэх боломжгүй байна. Иймд та бүхэн эхний хоёр асуудлаар санал хураалтад оролцож саналаа өгөх боломжтой. Ирэх жилийн дөрөвдүгээр сард болох Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дээрх асуудлаар дахин санал хураалт явуулах тул та бүхэн шалгуур хангасан хүнийг нэр дэвшүүлэх боломжтой юм.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах компанийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлантай холбоотой танилцуулга хийнэ.



Гүйцэтгэх захирал Г.Цогбадрах: Бидэнд итгэж хөрөнгө оруулалт хийсэн хувьцаа эзэмшигч та бүхэндээ энэ өдрийн мэнд хүргэе. Компани Санхүүгийн Зохицуулах Хороон (цаашид “Хороо” гэх)-оос олгосон тусгай зовишөөрлийн хүрээнд бүх төрлийн даатгалын бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байна, энэ онд даатгалын салбарын өсөлтийг дагаад хураамжийн орлого нэмэгдсэний зэрэгцээ нохон толбор ч багагүй хэмжээгээр нэмэгдсэн. Хувьцаагаа олон нийтэд санал болгох хэвлэл мэдээлэл, маркетингийн үйл ажиллагааны зардал, Монголын Хөрөнгийн Бирж, ҮЦТХТ гэх мэт маргэжлийн байгууллагуудын төлбөр гэхчилэн багагүй зардал гарсан. Хорооноос баталсан дүрэм, журмууд нь Даатгалын компани нь бусад Засгийн газрын үнэт цаас компанийн хувьцаанд хөрөнгө оруулалт хийхэд нарийн зохицуулалттай, нөөц сангийн хөрөнгөнөөс Засгийн газрын үнэт цааснаас бусад санхүүгийн хэрэгсэлд бага хэмжээгээр хөрөнгө оруулалт хийхээр заасан байдаг тул хөрөнгийнхөө ихэнх хувийг банкны хадгаламжид байршуулсан. 2018 оны 10 сарын 30-ны байдлаар хувьцааны 81 хувийг 16 аж ахуйн нэгж, 19 хувийг 1,482 иргэн эзэмшиж байгаа ба Ард Санхүүгийн Нэгдэл ХК-ийг эс тооцвол хувьцааны төвлөрөл маш бага байгаа нь сайшаалтай хэрэг юм.

Компанийн бүтэц, ТУЗ-ийн гишүүд, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт, анхдагч зах зээлийн захиалгын дүн, 2018 оны 11 сарын 28-ны өдрийн байдлаарх хоёрдогч зах зээлийн арилжааны мэдээг тус тус танилцуулав.

Гуравдугаар улирлын байдлаар нийт хөрөнгө, 19,252,000,000 төгрөг, нөөц сан 7,315,000,000 төгрөг, өөрийн хөрөнгө 10,002,000,000 төгрөг, төлбөрийн чадварын харьцаа үзүүлэлт 11.74%, хөрөнгийн өгөөж 10.9%-тай байгаа нь 2016, 2017 онуудынхаас нэмэгдсэн үзүүлэлттэй байна.

Компанийн Ахлах санхүүч Г.Баярбат дүрмийн санг нэмэгдүүлэх төслийг таницуулав.

Хувьцаа эзэмшигч С.Хуулай: Оруулсан хөрөнгийг яагаад бүгдийг нь дүрмийн санд нэмэхгүй байна вэ?

Ахлах санхүүч Г.Баярбат: Хорооноос дүрмийн сангийн доод хэмжээг 5 тэрбум тогрог болгох шаардлага тавьсны дагуу 1,5 тэрбум төгрөгийг дүрмийн санд бүртгэж, үлдсэн хөрөнгийг нэмж төлөгдсөн капитал буюу эздийн өмчид бүртгэнэ.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Оор асуулт байхгүй бол Дүрмийн санг 1,5 тэрбум тогроогоор нэмэгдүүлж, 5 тэрбум тогрог болгон нэмэгдүүлэхийг дэмжжэ гэлэг томьёолоор санал хураалт явуулж, Тооллогын Комиссын дарга Д.Энхбилэг санал хураалтын дүнг танилцуулахад саналын эрхтэй 18,532,078 ширхэг хувьцаа эзэмшигчдийн 99.99%-ийн саналаар тогтоолын төсөл дэмжигдэв. / Тооллогын Комиссын тогтоолд санал хураалтын дүнг дэлгэрэнгүй тусгав./

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд: Компанийн дүрмийн сан нэмэгдсэнтэй холбогдуулан зохих өөрчлөлт дүрэмд тусгагдана. Түүнчлэн компанийн дүрмийн төсөлд тусгагдсан компанийн үндсэн үйл ажиллагаа, эрх, үүрэг, хувьцаа эзэмшигч, Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн бүтэц, тэдгээрийн эрх, үүрэг, хувьцааг эргүүлэн худалдаж авах журмын талаар товч танилцуулга хийв.

Хурлын дарга Ч.Ганхуяг: Дүрмийн төсөлтэй холбогдуулан хувьцаа эзэмшигчдээс асуух асуулт байна уу ?

Хувьцаа эзэмшигч Д.Жаргалсайхан: Дүрмийн төслийн 10.8-д ногдол ашгийг бэлэн мөнгө, эд хөрөнгө, түүнчлэн компанийн болон бусад этгээдийн үнэт цаасаар төлнө гэж заасан байна. Бэлэн мөнгөөр олгохгүй гэсэн үг үү? Үүнийг ойлгохгүй байна. Компанийн ашгийн 30-50%-ийг ногдол ашиг болгон хуваарилана гэсэн ч дүрэмд тусгаагүй байгаа нь ямар учиртай вэ?

Үйл ажиллагаа эрхэлсэн захирал А.Батболд: Компанийн тухай хуулийн 46.7-д заасантай уялдуулсан зохицуулалт бөгөөд эдгээрийн аль ч хэлбэрээр ногдол ашгийг өгч болно.


Хурлын дарга Ч.Ганхуяг: Ногдол ашгийн бодлогод хувь хэмжээний талаар заасан бөгөөд түүнийхээ дагуу хуваарилах тул дүрэмд тусгах шаардлагагүй юм.

Хурлын дарга Ч.Ганхуяг Компанийн дүрмийг батлах гэдэг томьёллоор санал хураалт явуулж, Тооллогын Комиссын дарга Д.Энхбилэг санал хураалтын дүнг танилцуулахад 18,488,094 ширхэг хувьцаа буюу санал хураалтад оролцогчдын 99.76%-ийн саналаар тогтоолын төслийг дэмжив. / Тооллогын Комиссын тогтоолд санал хураалтын дүнг дэлгэрэнгүй тусгав./



Хурлын дарга Ч.Ганхуяг: Хурал амжилттай зохион байгуулагдаж, хэлэлцсэн асуудлуудаар нэгдсэн шийдэлд хүрлээ. Цаг заваа гаргаж хүрэлцэн ирсэнд баярлалаа, дараа жилийн ээлжит хурлаар дахин уулзатлаа түр баяртай гэснээр 16 цаг 45 минутад хурлыг хаав.

ХУРЛЫН ДАРГА

A handwritten signature in blue ink, consisting of stylized Cyrillic letters, likely representing 'Ч. ГАНХУЯГ'.

Ч.ГАНХУЯГ